



## Орос-Японы харилцаа ба Монголын тусгаар ТОГТНОЛЫН асуудал

Б.Майцэцэг

2019.03.28 4-801 тоот

# АГУУЛГА

1. Орос-Японы Алс Дорнод дахь бодлого
2. Ялтын бага хурал ба Монголын статус-кво
3. Орос-Японы харилцаан дахь газар нутгийн маргаант асуудал
4. Дүгнэлт



# 1. Орос-Японы Алс Дорнод дахь бодлого

Оросын Алс Дорнод дахь түрэлт:

- ▶ 16-17 зуунд Сибирь, Алс Дорнод /үнэт үслэг эдлэл/
- ▶ 18 зууны дунд үеэс Курилын арлаар тойрон Японы арал
- ▶ Боомтоо ашиглуулахыг шаардаж, Японд шахалт үзүүлж эхэлсэн

АНУ-ын АНД дахь ашиг сонирхол:

*/Хятад, Халим агнуур/*

- ▶ 1853 он Маттью Перри  Японд шахалт үзүүлсэн  Нээлттэй улс болсон

Япон 1639 он “Хаалттай улс”



1868 “Мэйжигийн шинэчлэл”  
“Нээлттэй бодлого”

АНД, Алс Дорнод, Солонгосын хойг:  
**Орос+Япон+Хятад+АНУ**

Оросын Алс дорнодод явуулах бодлого эрчимжихийн хирээр Орос Японы ашиг сонирхолын зөрчил үүсэх эхлэл болсон.

19-р зууны сүүл болоход Япон өөрийн АБ-г хангахын тулд Солонгосыг “бамбай улс” бодлого баримталсан.

Солонгосыг тусгаар улс болгох



Их гүрнүүдийг шахаж гаргах



Японы АБ-г хангагдана

1895 оны Япон Хятадын Шимоносекийн гэрээ:

- ▶ 1. Солонгосын тусгаар тогтголыг Хятад зөвшөөрсөн
- ▶ 2. Ляодуны хойг Японы талд шилжсэн
- ▶ 3. Хятадын худалдааны боомтыг Япон ашиглахыг Хятад зөвшөөрсөн

Солонгосын хойг: Орос+Япон+Хятад  Орос, Япон

## Их гүрнүүдийн ашиг сонирхол:

- ▶ 1902 он Англи+Япон холбоотны гэрээ */Германы санаачлага/*
- ▶ Орос +Франц, +-Герман

Германы зорилго: Европ  
дахь өөрийн нөлөөг  
өргөжүүлэхийн тулд  
Оросыг сулруулах



1905.08.10 Орос Японы энх тайвны хэлэлцээр

*/Т.Рузвельтын зуучлал/*

АНУ-ын ашиг сонирхол:  
АНУ-ын Филиппин дэхь  
ашиг сонирхолыг  
хөндүүлэхгүй байх

АНД дахь их гүрнүүдийн ашиг  
сонирхолын хуваагдал

Япон, АНУ  Орос, Хятад

## 2. Ялтын бага хурал ба Монголын статус-кво

1943.11 сард Кайр хотноо Т.Рузвельт, У.Черчилль, Чан Кайши (A+B+C)  
Хэлэлцсэн асуудал: Алс Дорнод дахь дайны голомтыг хэрхэх?

- ▶ Дайны дараах Азийн дэг журам
- ▶ Японы эсрэг хамтарсан цэргийн ажиллагаа
- ▶ Чан Кайши: дайны дараах БНМАУ-ын олон улсын статусыг сөхсөн.

1924.05.31 “Зөв-Хятадын гэрээ”-г үндэс болгон  
“дайны дараа БНМАУ-ыг Хятадын бүрэлдэхүүнд оруулах”

*АНУ нь БНМАУ-ын талаарх байр суурь тодорхой бус байсан ч уг асуудлаар Сталины байр суурь чухал болохыг мэдэж байсан.*



- ▶ 1944.07 сард АНУ-н дэд ерөнхийлөгч Хэнри Уоллес /төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд нэрт судлаач Оуэн Латтимор/ Алс Дорнодоор айлчилсан /3 сар: Сибирь, Төв Ази, Шинжань, Монгол/
- ▶ Уоллесын аялалын зорилго:
  - ▶ Чан Кайшитай уулзах, Гоминдань ХКН-н зөрчилдөөнийг намжаах
  - ▶ Зөв Хятадын хил орчмын Шинжань, Гадаад Монгол зэрэг маргаантай нутаг орчмыг тандан судлах, АНУ-ын монголын талаарх байр суурийг тодорхойлох



Монголын талаарх АНУ-ын бодлого тодорхойлогдсон:

*Монгол нь Оросын нөлөөний буюу Оросын “дагуул улс”*

▶ 1945.02.04-11-нд хуралдсан 3-н их гүрний **Ялтын бага хурал**

Сталин Японы эсрэг дайнд орох болзол: /**маш нууц**/

- ▶ *Монголын статус квог хэвээр хадгалах*
- ▶ *Японд алдсан газар нутгийг эргүүлж авах /Сахалин, Курилын арлууд/*
- ▶ *Хятадын Дайрен, Порт-Артурын усан боомтыг ашиглах*
- ▶ *Дорнод Хятад, Өмнөд Манжуурын төмөр замыг Хятадтай хамтарч ашиглах*

▶ АНУ нь Оросыг Японы эсрэг дайнд оролцуулахын тулд Сталины ямарч нөхцөлийг хүлээн зөвшөөрөхөд бэлэн байсан ба 1945.02.11 “**Крымийн хэлэлцээр**”-т 3 гүрний тэргүүнүүд Монголын оршин тогтнож буйг ОУ-н эрхзүйн үүднээс статус-квог /**status quo**/ хэвээр хадгалахыг зөвшөөрсөн.

▶ *Энэхүү статус кво нь Монгол нь Зөв-н нөлөөний хүрээнд тусгаар улсын хүрээнд оршин буйг ОУ-н эрхзүйн үүднээс баталгаажуулж өгсөн.*

- ▶ **Сталины ашиг сонирхол:** ЗХУ-ын алс Дорнодын аюулгүй байдлыг баталгаажуулах
- ▶ **АНУ-ын ашиг сонирхол:** Японы эсрэг Оросыг дайнд оруулах хугацааг тодорхой болгосон. */Германыг буулгаж авсны 3 сарын дараа/*

Ялтын бага гурлын шийдвэр



- ▶ 1946.02.13 Монгол-ДИУ-н хооронд дипломат харилцаа
- ▶ *Их гүрнүүд Монголын статус квог хүлээн зөвшөөрснөөр монголыг аажимдаа хүлээн зөвшөөрэхэд чиглэсэн найрсаг бөгөөд анхны том алхам байсан.*

### 3. Орос-Японы харилцаан дахь газар нутгийн маргаант асуудал

Курилын арал:

- ▶ Итуруп,  
Кунашир,  
Шикотан,  
Хабомай



- ▶ 3 гүрний Ялтын бага хурлын тохиролцоогоор Оросын эзэмшилд шилжсэн Курилын арлыг Япон улс нь өөрийн нутаг дэвсгэр гэж өнөөг хүртэл маргаж, эргүүлж авах асуудлыг Оросын талд тавьсаар байгаа.
- ▶ 1855, 1875 оны Орос Японы гэрээгээр Курилын арлууд нь Японы эзэмшилд байсан ба II дайны төгсгөлд Орос 1905 онд Японд алдсан газар нутгийг эргүүлж авах асуудлын хүрээнд Сахалинаас гадна Курилын арлыг багтаан үзсэн юм.

- ▶ Орос Японы хооронд 1956 онд дипломат харилцаа сэргэсэн ч, арлын маргаантай асуудлаас үүдэн өнөөг хүртэл энх тайвны гэрээ байгуулагдаагүй байна.
- ▶ Оросын тал Японтой газар нутгийн маргаантай асуудалгүй бөгөөд Курилын 4 арал Оросын нутаг дэвсгэр тул энэ асуудлаар Японтой хэлэлцэх шаардлагагүй гэсэг байр суурь баримталж ирсэн
- ▶ Гэвч хүйтэн дайн дуусч Оросын нөхцөл байдал өөрчлөгдөхөд Оросын ерөнхийлөгч М.С.Горбачёв, Б.Ельцины нар Японтой газар нутгийн шийдэгдээгүй асуудал байгааг хүлээн зөвшөөрсөн.

- ▶ Энэ үеэс Японы ЗГ Курилын арлыг эргүүлж авах талаар эрчимтэйгээр Оростой хэлэлцээ хийх бодлого явуулж эхэлсэн.
- ▶ Гэвч, дээрх 2 ерөнхийлөгчийн үед газар нутгийн маргаант асуудал шийдэгдэх явцад тодорхой ахиц гараагүй бөгөөд ерөнхийлөгч В.Путин энэ асуудалд оросын хатуу байр суурийг баримтлах болсноор Орос Японы харилцаан дахь маргаант асуудал хэвээр үлдсэн.

# Дүгнэлт

- ▶ Японы ерөнхий сайд Ш.Абэ маргаантай арлын асуудлыг “миний бие В.Путин ерөнхийлөгчийн үед шийдвэрлэнэ” хэмээн хэлсэн ч, энэ нь тийм амархан зүйл биш.
- ▶ 2018.9 сард болсон Владивостокт болсон “Дорнын ЭЗ-ийн чуулган”-р В.Путин *“газар нутгийн асуудлыг хэлэлцэлгүйгээр эхлээд Энх тайвны гэрээг байгуулж, 2 орны харилцааг шинэ шатанд гаргаж, хамтарч ажиллах”*-г санал болгосон.
- ▶ Харин Японы байр суурь бол “энх тайвны гэрээг байгуулах гол урьтал болзол Курилын арлын маргааныг шийдвэрлэх явдал” гэсэн байр суурьтай байна.



- ▶ Курилын арлыг тойрсон маргаанд ямар нэгэн шийдэл гарах эсэх нь тодорхойгүй бөгөөд уг асуудал нь дан ганц Орос Японтой хамааралтай асуудал бус, “Орос АНУ-ын харилцаа, цаашдын төлөв байдал” түүнээс үүдэн Оросын тус бүс нутагт явуулах бодлого тодорхойлогдох юм.
- ▶ Өөрөөр хэлбэл Орос АНУ-ын харилцаа зөрчилдөөнтэй байгаа энэ цаг үед Оросууд Японд уг арлын асуудалд буулт хийн, арлыг өгөх магадлал бага юм. Учир нь Японд шилжүүллээ гэж бодоход Япон АНУ-ын холбоотны гэрээний дагуу японд байгаа АНУ-ын цэргүүд Курилын аралд байрлахыг үгүйсгэж чадаргүй тул Орос нь ийм алдаа гаргахгүй нь лавтай.

- ▶ Нөгөө талаас Японы тал Ялтын бага хурлын үр дүнд Курилын арлыг Орост шилжүүлснийг хүлээн зөвшөөрөхгүйгээ мэдэгдэж, Крымийн хэлэлцээрийг хүчин төгөлдөр бус хэмээн үзэж, Оросыг Курилын арлыг шилжүүлж өгөхийг шаардаж байгаа нь Сталины тавьсан цогц болзолуудын нэг болох Монголын статус квогын асуудлыг хөндөж байгаа юм.
- ▶ Иймд Орос Японы цаашдын харилцааг сайтар ажиглаж, тандан судлаж байх зайлшгүй шаардлага бидэнд бий.